



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/32

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 19.1.5, 19.1.6, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/80, А/132, А/60 дугаар хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа”-ны зардалд 35,000,000 (гучин таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Уг зардлыг Засаг дарга ерөнхий дансны “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх “Нэг цэг”-ийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид зөвшөөрсүгэй.

3. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА 

Ш.ИДЭРБАЯСГАЛАН